

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР  
НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

Энэхүү гэрээг нэг талаас Увс аймгийн Тариалан сумын Засаг дарга З.Тэгшжаргал / цаашид "Засаг дарга" гэх/ нөгөө талаас МҮ- 013421/ Улаан-ам -1 / ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Шинэст -Өргөө ХК-ны захирал Д. Цогбаяр / цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх нар /Цаашид хамтад нь "Талууд" гэх/дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 06 дугаар сарын 23 ны өдөр Увс аймаг Тариалан суманд байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү гэрээ нь Увс аймаг Тариалан сумын Сангийн ширэг хэмээх газарт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын ард иргэдэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх.

**Хоёр. Засаг даргын эрх үүрэг**

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, саналыг нь авах

2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээллэх

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах.

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежмент төлөвлөгөөнд хяналт тавих.

2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлэх.

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх.

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах.

3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах.

3.1.4. Нийт ажлын байрны 50-иас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах.

3.1.5. Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн аймаг /сум, дүүрэг/-ийн иргэдэд мэдээлэл өгч байх.

3.1.6. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааны талаар тухайн сумын иргэдэд мэдээлэл өгч байх

3.1.7. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох.

3.1.8. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө хөтөлбөрийг биелүүлж ажиллах.

3.1.9. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.10. Толь, Тарвагатай багийн гэр цэцэрлэгийг дэмжиж иж бүрэн 6 ханатай гэрийг хандивлах.

3.1.11. Сумын ногоон байгууламжийг хариуцах 1 иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй дүнгээр гэрээ хийж ажиллуулах

3.1.12. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Хоёр живаа харгай" дэд хөтөлбөрийн хүрээнд 1 га талбайг хашиж хамгаалах зардлыг гаргах.

3.1.13. Нийгмийн хариуцлагын хүрээнд 2023 онд сумын орон нутгийг хөгжүүлэх сангийн дансанд 18,7 сая төгрөгийн хандивыг байршуулж, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх.

#### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо /цаашид "хороо" гэх/-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллана.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн нийтийн хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилож, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

#### **Тав. Гэрээний хэрэгжилт**

5.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг / сум, дүүрэг /- ийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15- ны дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

6.2. Энэхүү гэрээ нь тухайн шатны Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

## Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1 Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

### Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох.

8.1 Талууд гарын үсэг зурсан өдрөөр гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсон нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4 Гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УВС АЙМАГ ТАРИАЛАН  
СУМЫН ЗАСАГ ДАРГА



.....З. ТЭГШЖАРГАЛ

/Гарын үсэг/

ШИНЭСТ-ӨРГӨӨ ХК-НЫ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



.....Д. ЦОГБАЯР

/Гарын үсэг/